

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2022/261/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)  
Хөвсгөл аймаг  
2022 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар  
Утас: 88883317 Цахим хаяг: [erdenebaatara@audit.gov.mn](mailto:erdenebaatara@audit.gov.mn)  
Аудитын менежер: Э.Бат-Эрдэнэ  
Утас: 261628 Цахим хаяг: [baterdenee@audit.gov.mn](mailto:baterdenee@audit.gov.mn)  
Аудитор: Л.Мандахнаран  
Утас: 92118277 Цахим хаяг: [Mandakhnaran.L@audit.gov.com](mailto:Mandakhnaran.L@audit.gov.com)  
Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн  
Захирал: Ахлах аудитор: Б.Мядагмаа  
Утас: 99389208 Цахим хаяг: [ikhermurun.audit@gmail.com](mailto:ikhermurun.audit@gmail.com)  
Аудитор: Д.Оюундаваа  
Утас: 99389692 Цахим хаяг: [oyundavaa9692@gmail.com](mailto:oyundavaa9692@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

---

1. Аудитын санал дүгнэлт.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4-10
3. Аудитын тайлан .....	11
3.1 Ерөнхий зүйл .....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	12
3.4 Материаллаг байдал.....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	13
3.8 Аудитын гол асуудал.....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	14
4. Аудитын илрүүлэлт.....	14-15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	14

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЦАГААННУУР  
СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН  
ЭРХЛЭГЧ Т.ЦЭНДМАА ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР





**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2022.02.25 № 01/226  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЦАГААННУУР  
СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН  
ЭРХЛЭГЧ Т.ЦЭНДМАА ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР



## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>73,229,360.50</b>	<b>73,045,280.15</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>		
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	140,440.00	174,983.46
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	00.00	134,543.46
3351	Байгууллагаас авах авлага	140,440.00	40,440.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>		
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	73,088,920.50	72,870,296.69
35130	Эм боох материал	204,650.00	637,066.50
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	204,650.00	637,066.50
35410	Бичиг хэргийн материал	72,884,270.50	72,233,230.19
35420	Аж ахуйн материал	1,328,000.00	1,985,555.00
35440	Түлш, шатах тослох материал	29,464,375.10	33,217,683.43
35460	Хүнсний материал	5,788,750.00	3,232,532.40
35470	Бусад хангамжийн материал	7,739,910.00	12,332,860.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>28,563,235.40</b>	<b>21,464,599.36</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>314,556,906.40</b>	<b>367,586,096.54</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	314,556,906.40	367,586,096.54
39201	Барилга, байгууламж, орон сууц	302,926,906.40	340,185,746.54
39202	Хуримтлагдсан элэгдэл	316,544,008.10	315,239,904.31
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	-36,690,062.77	-49,013,909.21
39206	Хуримтлагдсан элэгдэл	28,332,650.00	51,004,676.00
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	-15,360,550.98	-8,207,470.36
39208	Хуримтлагдсан элэгдэл	21,241,678.63	32,830,024.63
39214	Бусад үндсэн хөрөнгө	-14,151,015.58	-7,077,677.83
39215	Хуримтлагдсан элэгдэл	7,700,000.00	2,400,000.00
39217	Ном	-7,700,000.00	00.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	3,010,199.00	3,010,199.00
39301	Програм хангамж	11,630,000.00	27,400,350.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	1,024,350.00	1,024,350.00
39303	Бусад биет бус хөрөнгө	-1,024,350.00	00.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>11,630,000.00</b>	<b>26,376,000.00</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>387,786,266.90</b>	<b>440,631,376.69</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>197,203.49</b>	<b>178,516.49</b>
<b>413</b>	<b>Өглөг</b>	197,203.49	178,516.49
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	197,203.49	178,516.49
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>387,589,063.41</b>	<b>440,452,860.20</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>387,589,063.41</b>	<b>440,452,860.20</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		
51101	Өмч: - төрийн	41,903,171.00	41,903,171.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	41,903,171.00	41,903,171.00
51210	Өмнөх үеийн үр дүн	49,621,208.26	103,308,535.55
51220	Тайлант үеийн үр дүн	49,621,208.26	50,444,738.76
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	00.00	52,863,796.79
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>296,064,684.15</b>	<b>295,241,153.65</b>
		<b>387,786,266.90</b>	<b>440,631,376.69</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>319,044,355.10</b>	<b>398,753,189.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>304,621,155.10</b>	<b>38,760,056.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	11,356,155.10	38,760,056.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	11,356,155.10	38,760,056.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	11,356,155.10	38,760,056.00
<b>123</b>	<b>Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг</b>	293,265,000.00	00.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	293,265,000.00	00.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>14,423,200.00</b>	<b>25,792,733.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	00.00	334,200,400.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	105,000.00	174,533.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	105,000.00	174,533.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	14,318,200.00	25,618,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	14,318,200.00	25,618,200.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>314,312,188.18</b>	<b>345,889,392.21</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>314,312,188.18</b>	<b>345,889,392.21</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	282,914,612.69	323,390,756.81
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	199,654,947.00	213,358,469.39
210101	Үндсэн цалин	162,017,747.00	147,275,684.09
210102	Нэмэгдэл	22,360,000.00	52,714,258.30
210104	Урамшуулал	15,277,200.00	13,368,527.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	25,526,467.00	28,933,154.75
210201	Тэтгэврийн даатгал	17,756,428.00	20,611,302.75
210202	Тэтгэмжийн даатгал	1,996,549.00	1,748,640.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,597,238.00	2,089,113.00
210204	Ажилгүйдлийн даатгал	370,840.00	396,727.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,805,412.00	4,087,372.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	11,634,728.00	19,461,397.60
210301	Гэрэл, цахилгаан	4,156,708.00	3,280,651.00
210302	Түлш, халаалт	7,376,020.00	16,038,746.60
210303	Цэвэр, бохир ус	102,000.00	142,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	4,660,625.00	15,767,872.71
210401	Бичиг хэрэг	510,450.00	1,137,500.00
210402	Тээвэр, шатахуун	1,696,850.00	2,675,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	00.00	103,245.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,453,325.00	402,800.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	11,449,027.71
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	17,609,020.00	17,326,676.50
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,250,810.00	680,716.50
210502	Хоол, хүнс	16,358,210.00	16,645,960.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	00.00	2,852,200.00
210604	Урсгал засвар	00.00	2,852,200.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	180,000.00	186,900.00
210702	Дотоод албан томилолт	180,000.00	186,900.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	674,060.00	2,179,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	324,060.00	1,639,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	350,000.00	540,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	22,974,765.69	23,324,285.86
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	99,000.00	1,028,700.00

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,095,100.00	2,727,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	19,780,665.69	19,568,385.86
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>31,397,575.49</b>	<b>22,498,635.40</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>180,000.00</b>	<b>1,000,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	180,000.00	1,000,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>28,307,620.49</b>	<b>15,498,635.40</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	28,307,620.49	15,498,635.40
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>2,909,955.00</b>	<b>6,000,000.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,909,955.00	6,000,000.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>4,732,166.92</b>	<b>52,863,796.79</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>4,732,166.92</b>	<b>52,863,796.79</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	41,903,171.00	296,064,684.15	44,889,041.34	382,856,896.49
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	-9,612,525.79	-9,612,525.79
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	41,903,171.00	296,064,684.15	35,276,515.55	373,244,370.70
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	4,732,166.92	4,732,166.92
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	41,903,171.00	296,064,684.15	49,621,208.26	387,589,063.41
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	41,903,171.00	296,064,684.15	49,621,208.26	387,589,063.41
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	823,530.50	823,530.50
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	41,903,171.00	296,064,684.15	50,444,738.76	388,412,593.91
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-823,530.50	00.00	-823,530.50
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	52,863,796.79	52,863,796.79
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	41,903,171.00	295,241,153.65	103,308,535.55	440,452,860.20

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>307,688,200.00</b>	<b>359,993,133.00</b>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	293,265,000.00	00.00
<b>123</b>	<b>Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг</b>	<b>293,265,000.00</b>	<b>00.00</b>
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	293,265,000.00	00.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>14,423,200.00</b>	<b>359,993,133.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	00.00	334,200,400.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>105,000.00</b>	<b>174,533.00</b>

Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	105,000.00	174,533.00
131106	Төсвийн урамшуулал	00.00	00.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>14,318,200.00</b>	<b>25,618,200.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	14,318,200.00	25,618,200.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>302,429,100.00</b>	<b>322,963,233.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>302,429,100.00</b>	<b>322,963,233.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>271,032,524.51</b>	<b>300,464,597.60</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>196,706,158.51</b>	<b>213,257,354.60</b>
210101	Үндсэн цалин	159,068,958.51	147,174,569.30
210102	Нэмэгдэл	22,360,000.00	52,714,258.30
210104	Урамшуулал	15,277,200.00	13,368,527.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>29,187,081.00</b>	<b>29,187,500.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	20,566,596.00	20,373,478.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,163,782.00	2,154,850.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,715,446.00	1,870,985.00
210204	Ажилгүйдлийн даатгал	430,915.00	434,937.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,310,342.00	4,353,250.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>11,408,245.00</b>	<b>15,800,000.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,252,995.00	3,280,651.00
210302	Түлш, халаалт	8,000,000.00	12,377,349.00
210303	Цэвэр, бохир ус	155,250.00	142,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>5,727,940.00</b>	<b>6,732,333.00</b>
210401	Бичиг хэрэг	570,900.00	170,555.00
210402	Тээвэр, шатахуун	1,950,500.00	3,137,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	00.00	103,245.00
210404	Ном, хэвлэл	104,040.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	174,533.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,862,500.00	3,146,700.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>23,112,400.00</b>	<b>23,671,410.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	928,720.00	784,800.00
210502	Хоол, хүнс	15,309,080.00	21,238,910.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,874,600.00	1,647,700.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>160,400.00</b>	<b>4,788,300.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	160,400.00	800,000.00
210602	Тавилга	00.00	170,100.00
210604	Урсгал засвар	00.00	3,818,200.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>180,000.00</b>	<b>186,900.00</b>
210702	Дотоод албан томилолт	180,000.00	186,900.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>817,900.00</b>	<b>3,039,100.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	367,900.00	2,599,100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	450,000.00	440,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>3,732,400.00</b>	<b>3,801,700.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	114,000.00	560,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,618,400.00	3,240,900.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>31,396,575.49</b>	<b>22,498,635.40</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>179,000.00</b>	<b>1,000,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	179,000.00	1,000,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>28,307,620.49</b>	<b>15,498,635.40</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	28,307,620.49	15,498,635.40
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>2,909,955.00</b>	<b>6,000,000.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,909,955.00	6,000,000.00

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	5,259,100.00	37,029,900.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	5,259,100.00	37,029,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,259,100.00	37,029,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	5,259,100.00	37,029,900.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	5,259,100.00	37,029,900.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-5,259,100.00	-37,029,900.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	359,818,600.00	338,319,964.60	21,498,635.4	94.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	359,818,600.00	338,319,964.60	21,498,635.4	94.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	358,818,600.00	337,319,964.60	21,498,635.4	94.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	216,203,100.00	213,257,354.60	2,945,745.4	98.6
210101	Үндсэн цалин	161,122,900.00	147,174,569.30	13,948,330.7	91.3
210102	Нэмэгдэл	39,803,000.00	52,714,258.30	-12,911,258.3	132.4
210104	Урамшуулал	15,277,200.00	13,368,527.00	1,908,673.0	87.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,187,500.00	29,187,500.00	0.0	100.0
210201	Тэтгэврийн даатгал	20,539,300.00	20,373,478.00	165,822.0	99.2
210202	Тэтгэмжийн даатгал	2,162,000.00	2,154,850.00	7,150.0	99.7
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,729,700.00	1,870,985.00	-141,285.0	108.2
210204	Ажилгүйдлийн даатгал	432,400.00	434,937.00	-2,537.0	100.6
210205	Эрүүл мэндийн даатгал	4,324,100.00	4,353,250.00	-29,150.0	100.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,800,000.00	15,800,000.00	3,000,000.0	84.0
210301	Гэрэл, цахилгаан	2,700,000.00	3,280,651.00	-580,651.0	121.5
210302	Түлш, халаалт	15,500,000.00	12,377,349.00	3,122,651.0	79.9
210303	Цэвэр, бохир ус	600,000.00	142,000.00	458,000.0	23.7
2104	Хангамж, бараа материалын зардал	7,031,900.00	6,957,800.00	74,100.0	98.9
210401	Бичиг хэрэг	424,300.00	170,555.00	253,745.0	40.2
210402	Тээвэр, шатахуун	2,000,000.00	3,237,300.00	-1,237,300.0	161.9
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	224,300.00	103,245.00	121,055.0	46.0
210404	Ном, хэвлэл	186,900.00	00.00	186,900.0	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,196,400.00	3,446,700.00	749,700.0	82.1
2105	Нормативт зардал	37,350,200.00	24,871,410.00	12,478,790.0	66.6
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,684,800.00	1,684,800.00	0.0	100.0
210502	Хоол, хүнс	33,717,700.00	21,238,910.00	12,478,790.0	63.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,947,700.00	1,947,700.00	0.0	100.0

<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	43,218,200.00	40,218,200.00	3,000,000.0	93.1
210601	Багаж, техник, хэрэгсэл	20,200,000.00	20,200,000.00	0.0	100.0
210602	Тавилга	16,200,000.00	16,200,000.00	0.0	100.0
210604	Урсгал засвар	6,818,200.00	3,818,200.00	3,000,000.0	56.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	186,900.00	186,900.00	0.0	100.0
210702	Дотоод албан томилолт	186,900.00	186,900.00	0.0	100.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	3,039,100.00	3,039,100.00	0.0	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,599,100.00	2,599,100.00	0.0	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	440,000.00	440,000.00	0.0	100.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	3801700.00	3801700.00	0.0	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	560,800.00	560,800.00	0.0	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,240,900.00	3,240,900.00	0.0	100.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	1,000,000.00	1,000,000.00	0.0	100.0
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,000,000.00	1,000,000.00	0.0	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	1,000,000.00	0.0	100.0
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	359,818,600.00	338,319,964.60	21,498,635.40	94.0
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	334,200,400.00	318,701,764.60	15,498,635.40	95.4
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	334,200,400.00	318,701,764.60	15,498,635.40	95.4
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	25,618,200.00	19,618,200.00	6,000,000.00	76.6
132001	Орон нутгийн төсвөөс	25,618,200.00	19,618,200.00	6,000,000.00	76.6

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>174,533.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>174,533.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>174,533.00</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>174,533.00</b>
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	174,533.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>174,533.0</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>174,533.00</b>
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	174,533.00

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд е-баримтын бүрдэлтэй холбоотой зөвлөмж тусгасан болно.

Аудитыг Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн аудитор Д.Оюундаваа, аудиторын туслах П.Ундармаа нар гүйцэтгэж, чанарын хяналтыг, ахлах аудитор Б.Мядагмаа хэрэгжүүлж, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Л.Мандахнаран, аудитын менежер Э.Бат-Эрдэнэ нар анхан шатанд, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар хоёр дахь шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг тус цэцэрлэгийн эрхлэгчийн 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 04 тоот албан бичгээр Ихэрмөрөн-Аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлсэн.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын хүүхдийн цэцэрлэг нь бага насны хүүхдийг өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжин, насан туршийн боловсролын суурь чадварыг эзэмшихэд дэмжин асрах, хамгаалах, хөгжүүлэх, сургалт, үйл ажиллагаагаар сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх үйл ажиллагаа явуулж байна.

2021 онд багш, сурагч, эцэг эхийн хамтын ажиллагаанд тулгуурласан хосолсон сургалтын хэлбэрийг нэвтрүүлэн, хичээл, сургалтын үйл ажиллагаанд бие даан суралцах арга зүйг хэрэгжүүлж, хоцрогдлыг нөхөх, арилгах үйл ажиллагааг дэмжин ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд: Нийгмийн даатгалын тухай хуульд заасан шимтгэлийн хувь хэмжээнд өөрчлөлт орж, Монгол Улсын засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 2021 оны 43-р тогтоол, “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах зааврыг шинэчлэх тухай” Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаал батлагдаж гарсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Бага” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 314.0 сая төгрөгөөс 2 хувиар буюу 6.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 5.0 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлангийн тодруулгыг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан загвараар бэлтгэсэн байна.

2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 52.8 сая төгрөгөөр буюу 13.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая. төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	0.1	0.2	0.1
Урьдчилгаа	0	0	0
Бараа материал	73.1	72.8	0.3
Үндсэн хөрөнгө	314.5	367.6	53.1
<b>Нийт хөрөнгө</b>	<b>387.8</b>	<b>440.6</b>	<b>52.8</b>
Өр төлбөр	0.2	0.1	0.1
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	387.5	440.4	52.9
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>387.8</b>	<b>440.6</b>	<b>52.8</b>

- Боловсролын яамны хөрөнгө оруулалтаар 9.9 сая төгрөгийн 9 нэр төрлийн гал тогооны тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн;
- Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын ИТХ-ийн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/111 дүгээр тогтоолоор элэгдлээрээ анхны өртгөө нөхөж, "0 үлдэгдэлтэй болсон боловч ашиглагдаж байгаа 37 нэр төрлийн 20.8 сая төгрөгийн анхны өртөг бүхий үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг нэмэгдүүлэн, 8.7 сая төгрөгөөр өртгийг шинэчлэн тогтоосон байна.
- Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/11 дүгээр тогтоолоор элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид ашиглалтын шаардлага хангахгүй 26 нэр төрлийн 9.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж данснаас хассан.
- Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын Засаг даргын 2021 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн А/83 дугаар бүхий 5313 м<sup>2</sup> газрыг Хүүхдийн цэцэрлэгт 40 жилээр эзэмшүүлэх тухай захирамжаар газрыг бүртгэлд авсан байна.
- Төсвийн хөрөнгөөр 30.9 сая төгрөгийн компьютер принтер, дохиоллын камер, гал тогооны тоног төхөөрөмж, сургалтын зориулалттай ширээ, сандал, тавилга эд хөрөнгө зэрэг сургалтын хэрэглэгдэхүүн бэлтгэх саналыг аймгийн орон нутгийн өмчийн газарт 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 32 тоотоор хүсэлт хүргүүлж, Хөвсгөл аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн А/608 тоот төсөвт зохицуулалт хийх тухай захирамжаар зохицуулалт хийгдэж тус хөрөнгүүдийг бэлдсэн байна.
- Тайлант хугацаанд 19.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал гарсан зэрэг тус тус нөлөөлсөн байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын ИТХ-ийн 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн хуралдааны 07 дугаар тогтоолоор тус цэцэрлэгийн төсвийг 324.8 сая төгрөгөөр баталсан байна.

Төсвийн жилийн явцад Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын ИТХ-ийн 2021 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн 08 дугаар тогтоолоор, тусгай зориулалтын шилжүүлгээр 285.1 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 14.3 сая төгрөг, урд оны дансны үлдэгдлээс 6.0 сая төгрөгөөр тус тус баталж нийт 305.4 сая төгрөг болж, анхны батлагдсан төсвөөс 19.4 сая төгрөгөөр бууруулж баталсан байна.

Төсвийн жилийн явцад Хөвсгөл аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн А/608 дугаар захирамжаар зохицуулалт хийгдэж, тус байгууллагын төсвийн зарлага 338.3 сая төгрөг болжээ.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх сургуулийн өмнөх боловсролын 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр нийт 359.8 сая төгрөгийн санхүүжилтийн, 334.2 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 25.6 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс тус тус авч, урсгал үйл ажиллагаанд 338.3 сая төгрөгийг зарцуулж 21.5 сая төгрөгийг төвлөрүүлж ажилласан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэлийг анхны батлагдсан төсөвтэй харьцуулахад 338.3 сая төгрөг буюу 94.5 хувьтай байгаа нь ковид-19 цар тахлын улмаас 190 хоног

хичээллэхээс 105 хоног хичээлэлж нормативт зардал, байр ашиглалт, урамшуулалт цалинтай холбоотой тогтмол зардал дутуу зарцуулагдсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт төсвийн дансаар нийт 0.2 сая төгрөгөгийн орлогыг Хөвсгөл аймгийн Боловсролын газрын даргын 2021 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн А/40 тоот тушаалаар, сургалтын үйл ажиллагааг эхлүүлэхтэй холбоотой анги танхимын ариутгал халдваргүйжүүлэлт хийх зориулалтын орлого авсан:

Нэмэлт төсвийн дансанд хүлээн авсан орлогын зарцуулалтын эрхийг Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалаар батлагдсан Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн журамд заасан баримтын бүрдлийг ханган НТН№1 маягтаар төрийн санд хүргүүлж эрх нээлгэж зориулалтын дагуу ариутгал халдваргүйжүүлэлтийг хийж ажилласан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Тайлант оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийхдээ Монгол Улсын ерөнхий аудиторын 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн А/111 дүгээр тушаалаар баталсан санхүүгийн тайлангийн аудит хийхэд баримтлах ерөнхий бодлого, чиглэлийн дагуу төсвийн хэмнэлтийн бодлого, зарцуулалт, шилэн дансны тухай хууль, журмын хэрэгжилт, өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт, ерөнхий чиглэлд тусгагдсан болон бусад асуудалд анхаарлаа хандуулсан.

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний талаар” 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгахад үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатай зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлтийг гаргаж ажилласан байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитад АОУС 701.8-д тодорхойлсон үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд гараагүй.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБООУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг

талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Монгол Улсын ерөнхий аудиторын “Шилэн дансны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт хэрэгжүүлэх ерөнхий чиглэл батлах тухай” 2021 оны А/108 дугаар тушаалаар батлагдсан чиглэлийн дагуу шилэн дансны мэдээллийг шалгахад 489.6 сая төгрөгийн 65 мэдээллийг ил тод байршуулахаас, 489.6 сая төгрөгийн 65 мэдээллийг ил тод байршуулж, мэдээллэсэн байдлын хэрэгжилт 100 хувьтай байна.

### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Худалдан авах ажиллагааны тухайд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 5 зөвлөмж өгөгдөж, зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татсан асуудал байхгүй байна.

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 80.9 сая төгрөгийн 4 алдаа зөрчил илэрснээс, 64.9 сая төгрөгийн 3 алдааг залруулж, 15.9 сая төгрөгийн 1 зөрчлийг давтан гаргахгүй байх талаар зөвлөмж өглөө.

### **4.1 Залруулсан алдаа**

Аудитын явцад санхүүгийн тайлагналтай холбоотой 64.9 сая төгрөгийн 3 алдааг залруулсан. Үүнд:

- ТБОНӨХБАУХАТ хуулийн хэрэгжилтийг шалгахад 37.4 сая төгрөгийн үлдэгдлийг бэлтгэн нийлүүлэгчтэй тооцоо нийлж үлдэгдлийг бүрэн баталгаажуулаагүй, гэрээ дүгнэсэн актгүй бүртгэсэн нь "Нягтлан бодох бүртгэлийн тухай" хуулийн 20.2.6.эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтад нийцэхгүй тул аудитын хугацаанд тооцоо нийлж гэрээ дүгнэж ажиллсан.
- Үндсэн хөрөнгийн тодруулгад үнэ төлбөргүй ирсэн болон дахин үнэлсэн хөрөнгийн дүн 27.5 сая төгрөгийн алдаатай толилуулсан байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4.үнэн зөв байх зарчим, гэсэн заалтад нийцэхгүй байгаа нь “Үнэн зөв” батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул аудитын хугацаанд толилуулж ажиллсан.
- Төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүнгийн талаар төсвийн гүйцэтгэлийн тайланийн танилцуулга бэлтгэж хавсаргаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 54.5.Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна: гэсэн заалттай нийцэхгүй байгаа тул аудитын хугацаанд толилуулсан залруулж ажиллсан.

#### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### 1. Анхан шатны баримт е-баримтаар нотлогдсон эсэх

1.1 Илрүүлэлт: Мөнгөн хөрөнгийн зарлагын 15.9 сая төгрөгийн гүйлгээ нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 13.1.4.доор дурдсан бараа, ажил, үйлчилгээний зардал Татварын ерөнхий хуулийн 28.5-д заасан дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримт, импортын бараанд татвар ногдуулж, гаалийн байгууллагад төлсөн тухай баримтаар баталгаажсан байх гэсэн заалтад нийцэхгүй байгаа нь "Иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 13.1.4.доор дурдсан бараа, ажил, үйлчилгээний зардал Татварын ерөнхий хуулийн 28.5-д заасан дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримт, импортын бараанд татвар ногдуулж, гаалийн байгууллагад төлсөн тухай баримтаар баталгаажсан байх гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 8 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

##### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Цагааннуур сумын хүүхдийн цэцэрлэг	4	80.9	3	64.9			-	-	1	15.9

#### БАТАЛГААЖУУЛАХ ХЭСЭГ

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРААС

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР Огноо:

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Э.БАТ-ЭРДЭНЭ Огноо:

АУДИТОР

Л.МАНДАХНАРАН Огноо: 11/25

ИХЭРМӨРӨН-АУДИТ ХХК

ХЯНАСАН: АУДИТОР

Б.МЯДАГМАА Огноо:

БОЛОВСРУУЛСАН: АУДИТОР

Д.ОЮУНДАВАА Огноо:

